

Урилга: 11-р сарын 19-нд Токиод болох “Япон-Монголын Бизнес уулзалт”

2018 оны 11-р сарын 19-ны өдөр Токио хотноо “Инвест Монголиа Токио” чуулган болон Япон-Монгол “Бизнесийн мэдээлэл солилцох уулзалт” 4 дахь удаагаа зохион байгуулахаар болж байна.

Япон улсын парламентын гишүүд, төрийн холбогдох албан тушаалтнууд, хувийн хэвшил, бизнесийн төлөөлөгчид зэрэг 200 гаруй төлөөлөгчид Японы талаас оролцох болно. Эдгээр төлөөлөгчидийн дунд уул уурхай, банк санхүү, үл хөдлөх хөрөнгө, худалдаа арилжаа, хөдөө аж ахуй зэрэг салбарыг хамарсан хувийн хэвшлийн компанийн төлөөлөл орж байна.

Монгол-Японы хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдаж, хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн нь хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд Япон Улсын бизнесийн салбарынхантай уулзаж, өөрийн компани, бизнес санал, төслөө танилцуулах боломж олгох үүднээс энэхүү мэдээлэл солилцох бизнес уулзалтад өргөнөөр оролцохыг урьж байна.

- ◆Огноо : 2018 оны 11-р сарын 19 (Даваа гараг)-ны өдрийн 09:00-18:00 (08:30-аас бүртгэл эхэлнэ)
- ◆Болох газар: JICA Ichigaya Building, 10-5 Ichigaya Honmuracho, Shinjuku-ku (“Инвест Монголиа Токио” чуулга уулзалт болох газар)
- ◆Хөтөлбөр
Бизнесийн мэдээлэл солилцох уулзалт (Урьдчилан бүртгүүлсэн Монгол болон Японы компаниуд тусгай ширээн дээр сууж, өөрийн компанийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх танилцуулгыг хийнэ)
- ◆Бидний зүгээс уулзалтанд зориулж цөөн тооны орчуулагч ажиллах тул оролцогч компаниуд өөрсдөө орчуулагчаа бэлдэх буюу дарааллын дагуу орчуулагчаар үйлчлүүлэхийг урьдчилан мэдэгдэж байна.
- ◆Хураамж: Үзэсгэлэн гаргагч болон хурлын төлөөлөгчид үнэ төлбөргүй
- ◆Чөлөөт оролцогч зааланд чөлөөтэй явж, хүмүүстэй нэрийн хуудас солилцож, босоо уулзалт хийх боломжтой.
- ◆Бизнес уулзалтад ширээ ашиглан компаниа сурталчилах: Ширээ түрээслэгч нь дараах линкээр <https://frontier-conference.com/j/registration/>, онлайн бүртгүүлэхээс гадна компанийхаа тухай 100-150 үгэнд багтсан танилцуулга, цахим хуудас, салбарын нэр зэрэг мэдээлэлээ 11-р сарын 12-ны (Даваа гараг) дотор staff@frontier.mn хаягаар ирүүлнэ үү. Ширээний тоо хязгаартай байгаа тул түрүүлж бүртгүүлсэн дарааллаар сурталчилгаа хийх боломжтой болохыг анхаарна уу. Сурталчилгаа хийгч ширээн дээр тавих бага хэмжээтэй баннер авчирч болохоос гадна тараах материал, компанийн хэвлэмэл танилцуулгыг тодорхой тоо хэмжээгээр авчрах шаардлагатай.
- ◆Бүртгүүлэх эцсийн хугацаа: 2018 оны 11-р сарын 12 (Даваа гараг)
- ◆Холбоо барих Фронтинер Жапан (Хариуцсан хүн Б.Бат-эрдэнэ)
Утас: +976 7575-5161
И-мэйл: staff@frontier.mn

